



APP

Азия Пасифик Пропертис ХК

2015 оны 04-р сарын 27 -ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 болон 63 дүгээр зүйлийн 63.5 дахь заалт, Тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн үйл ажиллагаа зогсонги байдалтай хэвээр үргэлжилж, алдагдалтай ажилласантай холбогдон ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт болон холбогдох тайлангуудыг компанийн цахим хуудсанд тогтмол байршуулж байлгах, цаашид компанийн үйл ажиллагааг идэвхижүүлэх талаар боломжит бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГАЛБАДРАХ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2015 оны 04-р сарын 27 -ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дах заалт болон Тооллогын комиссын 2 болон 3 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Өөрчлөн байгуулалт дуусч өөрчлөн байгуулах замаар бий болж буй ХХК-ийг бүртгүүлэх хүртэл компанийн ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай:
 1. Дангаасүрэн овогтой Галбадрах-ТУЗ-ийн ердийн гишүүн
 2. Банди овогтой Бямбажав-ТУЗ-ийн ердийн гишүүн
 3. Чимэддорж овогтой Энхбаяр-ТУЗ-ийн ердийн гишүүн
 4. Ламжав овогтой Отгончимэг-ТУЗ-ийн ердийн гишүүн
 5. Мөнхтөр овогтой Сосорбарам-ТУЗ-ийн ердийн гишүүн
 6. Чогсом овогтой Цогзолмаа-ТУЗ-ийн ердийн гишүүн
 7. Нацагдорж овогтой Батжин-ТУЗ-ийн хараат бус гишүүн
 8. Дэмчигжав овогтой Намсрайжав-ТУЗ-ийн хараат бус гишүүн
 9. Шаарийбуу овогтой Ганбат-ТУЗ-ийн хараат бус гишүүн
2. Компанийн тухай хууль тогтоомж, компанийн дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд даалгасугай.
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын зардал болон төсвийг 100,000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тооцож баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГАЛБАДРАХ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2015 оны 04-р сарын 27 -ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийг ХХК болгон өөрчлөн байгуулах,
өөрчлөн байгуулах төслийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 62.1.2, 62.7 дахь заалт, Тооллогын комиссын 2 дахь тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийг ХХК болгон өөрчлөн байгуулсугай.

Компанийг ХХК болгон өөрчлөн байгуулах төслийн 1.2 дахь заалтыг хувьцаа эзэмшигчдээс гарсан санал хүсэлтийг үндэслэн дор дурдсан байдлаар өөрчлөн найруулж 1 дүгээр хавсралтаар баталсугай.

1.2. Өөрчлөн байгуулах төслийн эсрэг саналтай байсан болон хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааг эргүүлэн худалдан авах үнэ нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрийн зах зээлийн хаалтын үнэ байна.

2. Хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн эрх хэрэгжүүлэх ажиллагааг төсөлд заасны дагуу хэрэгжүүлэхийг ТУЗ-өөс томилогдсон Ажлын хэсэгт, энэхүү ажиллагаанд хяналт тавьж, өөрчлөн байгуулах Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн тусалж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д үүрэг болгосугай.
4. Өөрчлөн байгуулах үйл ажиллагааг төсөлд заасны дагуу хэрэгжүүлж дууссаны дараа компанийн цахим хуудсаар үр дүнг мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Д.ГАЛБАДРАХ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Мөнгөл Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот